



Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг

31.2.Иргэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар дараах эрх эдэлнэ:

31.2.1.олон нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журам сахихыг бусдаас шаардах;

31.2.2.гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгуулах тухай асуудлыг холбогдох байгууллага, албан тушаалтанд тавих, шаардах;

31.2.3.гэмт халдлагаас эд хөрөнгө, өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг хуулийн хүрээнд хамгаалах;

31.2.4.хуульд заасан үүргээ биелүүлсний төлөө учирч болох эрсдэлээс хамгаалуулах;

31.2.5.хууль тогтоомжид заасан бусад.

Захиргааны хэлтэс

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар иргэний эрх, үүрэг

31.2 Иргэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар дараах эрх эдэлнэ:

**31.2.1 олон нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журам
сахихыг бусдаас шаардах**

**31.2.2 гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгуулах
тухай асуудлыг холбогдох байгууллага, албан тушаалтанд
тавих, шаардах**

**31.2.3 гэмт халдлагаас эд хөрөнгө, өөрийн болон бусдын амь
нас, эрүүл мэндийг хуулийн хүрээнд хамгаалах**

**31.2.4 хуульд заасан үүргээ биелүүлсний төлөө учирч болох
эрсдэлээс хамгаалуулах**

31.2.5 хууль тогтоомжид заасан бусад





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 4 дүгээр
сарын 28-ны өдөр

Дугаар 109

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 37.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан журмыг мөрдөж ажиллахыг төрийн бүх шатны байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.
3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт үүрэг болгосугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Хууль зүй, дотоод хэргийн сайд

Х.НЯМБААТАР



Засгийн газрын 2021 оны 109 дүгээр
тогтоолын хавсралт

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмаар төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны чиглэл, зарчим, хамрах хүрээ, зохион байгуулалт, санхүүжилт, арга хэлбэрийг тодорхойлж, түүнд холбогдох харилцааг зохицуулна.

1.2.Энэ журмын зорилго нь төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, албан тушаалтны ёс зүй, сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэх, гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, энэ үйл ажиллагаанд иргэн, хуулийн этгээдийг татан оролцуулах замаар төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгоход оршино.

1.3.Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхдээ хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, олон нийтийн сайн дурын оролцоонд түшиглэх, улс төрийн нөлөөллөөс ангид, нээлттэй, ил тод, тэгш шударгаар өрсөлдөх боломжтой байх зарчмыг баримтална.

1.4.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын агентлаг, бүх шатны Засаг даргын Тамгын газар, нутгийн захиргааны байгууллага, тэдгээрийн харьяа байгууллага, төрийн үйлчилгээний байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, нийтийн албан тушаалтны үйл ажиллагааг энэ журмын 2.1-д заасан олон нийтийн хяналтад хамруулна.

Хоёр.Үйл ажиллагааны чиглэл

2.1.Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг дор дурдсан чиглэлээр хэрэгжүүлнэ:

2.1.1.Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан мэдээллийн ил тод, нээлттэй байдал;

2.1.2.Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийн ил тод, нээлттэй байдал;

2.1.3.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т заасан иргэний эрх, мөн хуулийн 34, 36, 38, 39 дүгээр зүйлийн хэрэгжилт;

2.1.4.Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 6.1-д заасан төрийн байгууллагын хүлээх нийтлэг үүргийн хэрэгжилт;

2.1.5.Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д заасан саналыг авсан эсэх, мөн зүйлийн 62.2-т заасан хэлэлцүүлгийг хийсэн эсэх;

2.1.6.Төсвийн тухай хуульд заасан олон нийтийн оролцоог хангах, олон нийтийг хяналт тавих боломжоор хангасан эсэх;

2.1.7.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмын хэрэгжилтийн байдал;

2.1.8.Албан тушаалтан хандив авах, давхар ажил эрхлэх, төлбөр авах, төлөөлөл хэрэгжүүлэх зэрэг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн эсэх;

2.1.9.Албаны үүргээ хэрэгжүүлэх явцад үл ойлгогдохуйц нөхцөл байдал үүсгэсэн, ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл байдалд шийдвэр гаргасан, үйл ажиллагаа эрхэлсэн эсэх;

2.1.10.Тодорхой салбарт болон орон нутаг, нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтнаас батлан мөрдүүлсэн шийдвэр нь дор дурдсан нөхцөл байдлыг үүсгэсэн эсэх:

2.1.10.1.хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй;

2.1.10.2.ил тод, нээлттэй байдлыг хязгаарласан;

2.1.10.3.ашиг хонжоо олох, давуу байдал үүсгэх боломж бүрдүүлсэн;

2.1.10.4.үндэслэлгүй төлбөр хураамж тогтоосон;

2.1.10.5.хуулиар хориглосон, хязгаарласан хэм хэмжээ тогтоосон эсэх;

2.1.10.6.хууль тогтоомжоор зөвхөн тухайн албан тушаалтанд олгосон эрх хэмжээг бусдад шилжүүлсэн, боломж олгосон;

2.1.10.7.хууль тогтоомж зөрчин аливаа бүтэц, нэгж, орон тоо, эрх хэмжээ бий болгосон эсэх;

2.1.10.8.аливаа байгууллага, иргэн шударгаар өрсөлдөх боломжийг хязгаарласан, сонгон шалгаруулалтын зарчмыг алдагдуулсан эсэх;

2.1.10.9.улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгийг үр дүнгүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн;

2.1.10.10.иргэд, олон нийтийн оролцоо, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шийдвэрлэх явцын мэдээллээр хангагдах боломжийг хязгаарласан;

2.2.Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэгч нь цахим хуудас, нээлттэй мэдээлэл, өгөгдлийн санд байршуулсан нийтийн албан тушаалтны хувийн ашиг

сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ) эргэлзээтэй гэж үзвэл холбогдох мэдээллийг зохих байгууллагад хүргүүлж болно.

2.3.Төрийн байгууллага, албан тушаалтан нь байгууллага, салбарын онцлог, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, чиг үүргээс хамааран өөрийн байгууллага, албан хаагчдын гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, гарч болзошгүй шалтгаан нөхцөлийг тодорхойлох, арилгахад чиглэсэн арга хэмжээг олон нийтийн хяналтын оролцоотой хэрэгжүүлнэ.

Гурав.Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх хэлбэр

3.1.Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг дараахь хэлбэрээр хэрэгжүүлнэ:

3.1.1.төрийн байгууллагын цахим хуудсанд мониторинг, дүн шинжилгээ хийж, тайлан, мэдээлэл, санал боловсруулах;

3.1.2.нээлттэй өгөгдлийн системийг ашиглах, харьцуулах, судлах, тайлан, мэдээлэл, санал боловсруулах;

3.1.3.тухайн байгууллагын нээлттэй мэдээ, мэдээлэлтэй танилцах, судалгаа хийх, мэдээлэл, санал боловсруулах;

3.1.4.төрийн байгууллагын үзүүлж буй үйлчилгээний явцад ажиглалт хийх, тайлан, мэдээлэл, санал боловсруулах.

3.2.Төрийн байгууллага, албан тушаалтан нь энэ журмын 2.1-д заасан чиглэлээр олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай төрийн болон албаны, хувь хүний нууцад хамаарахаас бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.

3.3.Энэ журмын 4.1-д заасан этгээд нь төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлсэн тухай тайлан, мэдээлэл, илтгэх хуудсыг цаашид авах арга хэмжээний саналын хамт Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, салбар зөвлөл болон энэ журмын 1.4-т заасан байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

3.4.Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлсэн тухай тайлан, мэдээлэл, илтгэх хуудас, цаашид авах арга хэмжээний санал нь иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй байна.

Дөрөв.Зохион байгуулалт, сонгон шалгаруулалт

4.1.Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх этгээдийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр шалгаруулна. Нээлттэй сонгон шалгаруулалтад иргэн, иргэдийн бүлэг, судалгаа шинжилгээний болон төрийн бус байгууллага оролцож болно.

4.2.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, салбар зөвлөл нь энэ журмын 6.2, 6.3-т заасан чиглэлийн хүрээнд сонгон шалгаруулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулна.

4.3.Энэ журмын 4.1-д заасан этгээд нь дор дурдсан шаардлагыг хангасан байна:

4.3.1.хяналт хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтантай сүүлийн 2 жилийн хугацаанд хамтран ажиллаагүй буюу гэрээний дагуу ажил, үйлчилгээ эрхэлж байгаагүй;

4.3.2.хяналт хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтантай сүүлийн 2 жилийн хугацаанд хөдөлмөрийн гэрээ болон гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж ажиллаагүй байх;

4.3.3.хяналт хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтнаас сүүлийн 2 жилийн хугацаанд бэлэг, хандив, санхүүгийн дэмжлэг, туслалцаа аваагүй, мөн төлөөлөл хэрэгжүүлээгүй байх;

4.3.4.олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээдийн гэр бүл, найз нөхөд, нэгдмэл сонирхолтой этгээд нь хяналт хэрэгжүүлэх байгууллагад ажилладаггүй байх;

4.3.5.хяналт хэрэгжүүлэх байгууллагын эрх бүхий албан тушаалтантай хамаарал бүхий этгээд биш байх.

4.4.Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэгч нь төрийн хяналт шалгалт хийх эрхгүй байх бөгөөд хяналтыг хэрэгжүүлэхдээ тухайн байгууллага, албан тушаалтны эрх хэмжээний асуудлаар шийдвэр гаргах болон байгууллагын дотоод үйл ажиллагаанд оролцохыг хориглоно.

Тав.Санхүүжилт

5.1.Энэ журмын 1.4-т заасан байгууллага тухайн төсвийн жилд хэрэгжүүлэх олон нийтийн хяналтын чиглэлийг тодорхойлж, холбогдох зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж болно. Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэгч нь хяналт хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны зардлын тодорхой хэсгийг сайн дурын үндсэн дээр эсхүл, үнэ төлбөргүй хариуцаж болно.

5.2.Энэ журмын 1.4-т заасан байгууллагаас ирүүлсэн саналыг үндэслэн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, салбар зөвлөл нь тухайн жилд 6.2, 6.3-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг төсөвт тусган, гэрээний үндсэн дээр санхүүжүүлж болно.

Зургаа.Бусад

6.1.Энэ журмын 4.1-д заасан этгээдээс олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхийн өмнө Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу мэдэгдэл гаргуулан авч болно.

6.2.Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой сургалт, сурталчилгааны ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, салбар зөвлөл хариуцан гүйцэтгэх ба тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий бусад байгууллагатай хамтран ажиллана.

6.3.Энэ журмын 1.4-т заасан байгууллага, албан тушаалтан олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, холбогдох албан тушаалтанд хуульд заасан хариуцлагыг ногдуулах, дэвшүүлсэн саналыг судалж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах арга хэмжээг авах үүрэгтэй.

6.4.Энэ журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---



НИЙСЛЭЛИЙН
“ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 02 сарын 11 өдөр

Дугаар А/03

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Журам батлах тухай” 109 дүгээр тогтоол, “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 9.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын хүрээнд 2026 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төлөвлөгөөний дагуу ажлыг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс (Ц.Гүрбадам)-т даалгасугай.

ДАРГА



Б.МӨНХБАТ

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын
даргын 2026 оны 02 дугаар сарын 11-ний
өдрийн 1 дугаар тушаалын хавсралт



“НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ 109 ДҮГЭЭР ТОГТООЛ
“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТЫГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ”-ЫН ХҮРЭЭНД
2026 ОНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Тогтоолын тэргүү	Батлагдсан огноо	Дугаар	Хугацаа	Хариуцах хэлтэс
д/д	Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам	2021-04-28	109	Улирал бүр	
Заалт				Шалгуур үзүүлэлт	Хамтран хэрэгжүүлэх
Нэг.Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан мэдээллийн ил тод, нээлттэй байдал					
1.1.Байгууллагын үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээ, мэдээллийг ил тод мэдээлэх				Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна	Захиргааны хэлтсийн Ахлах мэргэжилтэн, Мэдээллийн технологийн хэлтэс, Төлөвлөлт судалгааны хэлтэс
1.2.Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээллийг нээлттэй мэдээлэх					
1.3.Газрын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, нийгмийн сүлжээний хаяг зэрэг мэдээллийг нээлттэй мэдээлэх					
1.4.Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүнг мэдээлэх					
1.5.Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загварыг мэдээлэх					
1.6. https://investpro.ub.gov.mn/#/projects системд нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдлийг мэдээлэх					

Хоёр.Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийн ил тод, нээлттэй байдал		
2.1.Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн мэдээллийг https://info.shilendans.gov.mn/ сайтад хуулийн хугацаанд байршуулах	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна	Захиргааны хэлтсийн Ахлах мэргэжилтэн, Санхүү, аж ахуйн хэлтэс
2.2.Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийг https://info.shilendans.gov.mn/ сайтад хуулийн хугацаанд байршуулах		
2.3.Газрын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг https://info.shilendans.gov.mn/ сайтад хуулийн хугацаанд байршуулах		
Гурав.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсгийн хэрэгжилт;		
3.1.Олон нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журам сахихыг бусдаас шаардах чиглэлээр постер мэдээлэл бэлтгэн дотоод сүлжээнд байршуулах	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэн ажилласан байна	Захиргааны хэлтсийн Ахлах мэргэжилтэн
3.2.Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгуулах тухай постер мэдээлэл бэлтгэн дотоод сүлжээнд байршуулах		
3.3.Гэмт хадлагаас эд хөрөнгө, өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг хуулийн хүрээнд хамгаалах чиглэлээр постер мэдээлэл бэлтгэн дотоод сүлжээнд байршуулах		
Дөрөв.Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн хэрэгжилт;		
4.1.Олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвлүүлэх чиглэлээр нөлөөллийн постер мэдээлэл бэлтгэн дотоод сүлжээнд байршуулах	Авлигын эсрэг хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэн ажилласан байна	Захиргааны хэлтсийн Ахлах мэргэжилтэн
4.2.Авлигатай тэмцэх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах, хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулах, бүртгэх, хянах, зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах		Захиргааны хэлтсийн Ахлах мэргэжилтэн
4.3.Газрын ажилтны Ёс зүйн дүрмийг шинэчлэн батлан гаргахын өмнө нийт ажилтнуудаас санал авч ажиллах		Захиргааны хэлтэс, Ёс зүйн дэд хороо
4.4.Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх чиглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх		Т.Ичинхорлоо
Тав.Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д заасан саналыг авсан эсэх,		
5.1.Захиргааны хэм хэмжээний актын төслийг тухайн захиргааны байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт 30-аас доошгүй хоногийн хугацаанд байрлуулж ажиллах	Захиргааны ерөнхий хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэн ажилласан байна	Захиргааны хэлтсийн Ахлах мэргэжилтэн

Зургаа.Бусад чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх ажил		
6.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмын хэрэгжилтийн байдал	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэн ажилласан байна	Захиргааны хэлтэс, Төлөвлөлт судалгааны хэлтэс
6.2.Албан тушаалтан хандив авах, давхар ажил эрхлэх, төлбөр авах, төлөөлөл хэрэгжүүлэх зэрэг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн эсэх		Захиргааны хэлтсийн Ахлах мэргэжилтэн
6.3.Албаны үүргээ хэрэгжүүлэх явцад үл ойлгогдохуйц нөхцөл байдал үүсгэсэн, ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл байдалд шийдвэр гаргасан, үйл ажиллагаа эрхэлсэн эсэх		Захиргааны хэлтсийн Ахлах мэргэжилтэн

---oOo---



Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаа

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулга (2023 онд батлагдаж, 2024 оноос мөрдөгдөж эхэлсэн) болон Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолын хүрээнд "Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаа"-ны хэрэгжилт

1. Олон нийтийн оролцоо гэж юу вэ?

- Иргэд, төрийн бус байгууллагууд худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тендер шалгаруулалт, гэрээний хэрэгжилт болон чанарт хяналт тавих үйл явц юм.
- Иргэдийн бүлэг: Тодорхой төсөл, арга хэмжээг (жишээ нь: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр) иргэд өөрсдөө гардан гүйцэтгэх боломж хуулиар нээлттэй болсон.

2. Хэрэгжилтийн өнөөгийн байдал (2024-2026)


- Цахим шилжилт: Бүх тендер шалгаруулалт www.tender.gov.mn системээр дамжин нээлттэй явагдаж байна.
- Шилэн хяналт: Тендерийн үнэлгээний хорооны дүгнэлт, шалгарсан оролцогч, гэрээний үнэ иргэдэд 24/7 нээлттэй болсон.
- Гүйцэтгэлийн хяналт: Иргэд тухайн барилга, зам засварын ажил дээр "Олон нийтийн хяналтын зөвлөл" байгуулан чанарыг газар дээр нь шалгах боломж бүрдсэн.

3. Иргэн Таны оролцох 3 суваг

1. Төлөвлөлт: Орон нутгийн хөгжлийн сангийн (ОНХС) хөрөнгөөр юу хийхийг санал асуулгаар шийдвэрлэх.
2. Хяналт: Тендерт шалгарсан компани ажлаа хугацаандаа, стандартын дагуу хийж буйг хянах.
3. Үнэлгээ: Гүйцэтгэсэн ажил чанаргүй бол тайлан бичиж, холбогдох байгууллагад гомдол гаргах.

ТЕНДЕР ТАНЫ НҮДЭН ДЭЭР ИЛ ТОД БОЛЛОО

“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ нь бүх худалдан авах ажиллагаагаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн дагуу иргэдийн хяналт дор явуулж байна.

 Хуулиар иргэд зөвхөн хөндлөнгөөс харах бус, зарим жижиг төсөл дээр “Иргэдийн бүлэг” байгуулан хамтран ажиллах эрх нээлттэй болсон.

 **Юуг мэдэх хэрэгтэй вэ?**

- Тендерийн мэдээлэл нээлттэй юу?
- Шалгаруулалт шударга болсон уу?
- Ажлын гүйцэтгэл чанартай байна уу?

 **Тендерийн мэдээллийг хянах: tender.gov.mn**

 **Нийслэлийн хөрөнгө оруулалтын газарт хэрэгжиж буй төслүүдтэй танилцах: invest.ub.gov.mn**

#НХОГ #ХудалданАвахАжиллагаа #Тендер #ИргэнийХяналт
#ИлТодБайдал #109тогтоол #ОНХС

АЛБАН ТУШААЛТАНД ЮУГ ХОРИГЛОДОГ ВЭ?

Монгол Улсын Засгийн газрын 109 дүгээр тогтоол болон "Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-д заасан:

1. ХАНДИВ, БЭЛЭГ СЭЛТ АВАХЫГ ХОРИГЛОНО 🎁🚫

- Албан тушаалтан өөрийн үүрэгт ажилтай нь холбогдуулан иргэн, хуулийн этгээдээс хандив, бэлэг авах, үнэ төлбөргүй үйлчилгээ авахыг хатуу хориглоно.
- **Иргэний хяналт:** Танаас эсвэл бусдаас бэлэг, хандив нэхсэн эсвэл авсан бол энэ нь хууль зөрчсөн үйлдэл юм.

2. ДАВХАР АЖИЛ ЭРХЛЭЛТ 📁📁

- Нийтийн албан тушаалтан нь багшлах, эрдэм шинжилгээний болон бүтээлч ажлаас бусад цалинтай ажил, албан тушаалыг давхар эрхлэхийг хориглоно.
- **Иргэний хяналт:** Төрийн албан хаагч хувийн компанид захирал хийх, өөр байгууллагад гэрээгээр ажиллаж буй эсэхийг хянах.

3. ТӨЛБӨР АВАХЫГ ХОРИГЛОНО 💰🚫

- Албан үүргээ гүйцэтгэсний төлөө иргэдээс ямар нэгэн нэмэлт төлбөр, шагнал, урамшуулал авахыг хориглоно.
- **Иргэний хяналт:** Төрийн үйлчилгээг түргэтгэх эсвэл шийдвэр гаргасны төлөө "гар цайлгах" зүйл нэхэж буй эсэхийг хянах.

4. ТӨЛӨӨЛӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ 🤝🚫

- Албан тушаалтан өөрийн ажиллаж буй байгууллагынхаа эсрэг иргэн, хуулийн этгээдийн төлөөлөгч, өмгөөлөгчөөр ажиллахыг хориглоно.
- **Иргэний хяналт:** Байгууллагынхаа ашиг сонирхолд харшлах хувийн компани, иргэний талд зуучлах, лобби хийж буй эсэхийг анхаарах.

МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГ

Газрын албан хаагчид нь "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийг чанд мөрдөх үүрэгтэй. Хэрэв зөрчил илэрвэл Та хаана хандах вэ?

1. Хаана мэдээлэх вэ?

- **АТГ-ын шуурхай утас:** 11-10 (24/7 нээлттэй, дуудлага үнэ төлбөргүй)
- **Цахим хуудас:** iaas.mn (Авлигатай тэмцэх газар)
- **Нийслэлийн санал хүсэлт:** 11-11
- **НХОГ-ын Ёс зүйн дэд хороо:** invest.ub.gov.mn (Байгууллагын дотоод хяналт)

2. Мэдээлэгчийг хамгаалах (Хуулийн заалт)

- **Нууцлал:** Таны мэдээлэл, хувийн нууцыг чандлан хадгална.
- **Дарамт шахалтаас хамгаалах:** Мэдээлэл өгсний төлөө ажлаас халах, дарамт шахалт үзүүлэхээс хуулиар хамгаална.
- **Эрсдэлээс сэргийлэх:** Таны болон таны гэр бүлийн аюулгүй байдалд эрсдэл үүсвэл төрөөс хамгаалалт хүсэх эрхтэй.

#НХОГ #ЗөрчлийгМэдээлэх #МэдээлэгчийгХамгаалах #АвлигынЭсрэг
#ШударгаЁс #109тогтоол #Улаанбаатар



ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦ БА ХЯНАЛТ

✓ Монгол Улсын Засгийн газрын 109 дүгээр тогтоолын 2.1.9-д заасан "Шийдвэр гаргах явцад ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн эсэх"-ийг хянах чиглэлээр:

1. Үл ойлгогдохуйц нөхцөл байдал ?

- Албан тушаалтан шийдвэр гаргахдаа үндэслэлээ тодорхой тайлбарлаагүй, үйл явц нь бүрхэг, нууцлагдмал байх.
- **Иргэний хяналт:** "Яагаад ийм шийдвэр гарав?", "Ямар шалгуураар энэ компани шалгарав?" гэдэг нь ойлгомжгүй байвал энэ нь хянах үндэслэл болно.

2. Ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр

- Албан тушаалтан өөрийн гэр бүл, төрөл садан, найз нөхөд эсвэл хамаарал бүхий этгээдийнхээ ашиг сонирхолд нийцсэн шийдвэр гаргах.
- **Иргэний хяналт:** Тухайн шийдвэр гаргагч нь гүйцэтгэгч талтай ямар нэгэн холбоотой эсэхийг нягтлах.

3. Өөртөө давуу байдал үүсгэх

- Албан тушаалтан эрх мэдлээ ашиглан ирээдүйд өөртөө эсвэл бусдад давуу байдал, эдийн засгийн ашиг хонжоо олох боломжийг бүрдүүлсэн үйл ажиллагаа эрхлэх.
- **Иргэний хяналт:** Шийдвэр гаргасны дараа тухайн албан тушаалтан эсвэл түүний хамаарал бүхий этгээдэд ямар нэгэн ашигтай нөхцөл байдал үүссэн эсэхийг анхаарах.

#НХОГ #ШийдвэрГаргалт #АшигСонирхлынЗөрчил #ИргэнийХяналт
#ИлТодБайдал #109тогтоол #Улаанбаатар

“НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР” ОНӨААТҮГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ 109 ДҮГЭЭР ТОГТООЛ
 “ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТЫГ
 ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ”-ЫН ХҮРЭЭНД 2026 ОНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
 (ХАГАС ЖИЛ)

2026 оны 06 дугаар сарын 02

Улаанбаатар хот

Д/д	Тогтоолын тэргүү	Батлагдсан огноо	Дугаар	Биелэлт	Биелэлтийн хувь
	Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам	2021-04-28	109	Улирал бүр	
Нэг.Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан мэдээллийн ил тод, нээлттэй байдал					
1.1.	Байгууллагын үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээ, мэдээллийг ил тод мэдээлэх			Тайлант хугацаанд манай газраас хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээ, үйл ажиллагааны мэдээллийг ил тод мэдээлэх ажлын хүрээнд нийт 73 мэдээг газрын фэйсбүүк (https://www.facebook.com/nkhog) хуудас болон вэб хуудсанд (https://invest.ub.gov.mn/) нийтлэв.	100 хувь
1.2.	Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээллийг нээлттэй мэдээлэх			Газрын үйл ажиллагааны статистик мэдээллийг нээлттэй мэдээлэх ажлын хүрээнд 2026 оны нэгдүгээр улирлын байдлаар барилга болон зургийн ажлын мэдээллийг газрын вэб хуудсанд дараах холбоосоор мэдээлэв. (https://invest.ub.gov.mn/wp-content/uploads/2024/03/BU-2026.05.29.pdf), (https://invest.ub.gov.mn/wp-content/uploads/2024/03/ZU-2026.05.29.pdf)	100 хувь
1.3.	Газрын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, нийгмийн сүлжээний хаяг зэрэг мэдээллийг нээлттэй мэдээлэх			Газрын чиг үүрэг (https://invest.ub.gov.mn/department/about/), бүтэц, зохион байгуулалтыг газрын вэб хуудас дахь дараах холбоосоор нээлттэй мэдээлж ажиллав. (https://invest.ub.gov.mn/department/management/), (https://invest.ub.gov.mn/department/finance/), (https://invest.ub.gov.mn/department/laws/), (https://invest.ub.gov.mn/department/order/), (https://invest.ub.gov.mn/department/%d0%b7%d1%83%d1%80%d0%b0%d0%b3-%d1%82%d3%a9%d1%81%d0%bb%d0%b8%d0%b9%d0%bd-%d1%85%d1%8d%d0%bb%d1%82%d1%8d%d1%81/), (https://invest.ub.gov.mn/department/project/), (https://invest.ub.gov.mn/department/it/), нийгмийн сүлжээний хаяг (https://www.facebook.com/nkhog)	100 хувь
1.4	Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүнг мэдээлэх			Улс болон нийслэлийн төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүнг газрын вэб хуудас дахь дараах холбоосоор нээлттэй мэдээлж ажиллав. (https://invest.ub.gov.mn/wp-content/uploads/2024/03/shilen26.pdf)	100 хувь

1.5. Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загварыг мэдээлэх	Тус ажлын хүрээнд газрын вэб хуудас дахь дараах холбоосуудаар Үйлчилгээний төрөл, бүрдүүлэх баримт бичиг, түүний загварыг нээлттэй мэдээлж ажиллав. (https://invest.ub.gov.mn/laws/jishiq/) (https://invest.ub.gov.mn/doc/zurag-tuslin/)	100 хувь
1.6. https://investpro.ub.gov.mn/#/projects системд нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдлийг мэдээлэх	Манай газраар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний мэдээллийг https://investpro.ub.gov.mn/#/projects системд дүүрэг, хороогоор ангилан харах боломжтойгоор нээлттэй мэдээлж байна.	100 хувь
Хоёр. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийн ил тод, нээлттэй байдал		
2.1. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн мэдээллийг https://info.shilendans.gov.mn/ сайтад хуулийн хугацаанд байршуулах	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж 5 сая дээш төгрөгийн худалдан авалтыг тухай бүр шилэн дансанд байршуулан ажиллаж байна. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл тус тус www.shilendans.gov.mn цахим сайтад зааврын дагуу хуулийн хугацаанд нээлттэй байршуулах мэдээлэл байхгүй.	100 хувь
2.2. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийг https://info.shilendans.gov.mn/ сайтад хуулийн хугацаанд байршуулах	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж мэдээллийг тухай бүр нь байршуулан нээлттэй ил тод ажиллаж байна. Хагас жилийн урьдчилсан (2026.05.29) байдлаар 5 сая төгрөгөөс дээш орлогын 170 ажил гүйлгээний 14.3 тэрбум төгрөг, зардлын 171 ажил гүйлгээний 17.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийн мэдээг тухайн сар бүр хуульд заасан хугацаанд www.shilendans.gov.mn сайтад бүртгэж байршуулсан.	100 хувь
2.3. Газрын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг https://info.shilendans.gov.mn/ сайтад хуулийн хугацаанд байршуулах	Газрын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг https://info.shilendans.gov.mn/ сайтад 2026 оны байдлаар 5 удаа хуулийн хугацаанд нь байршуулав.	100 хувь
Гурав. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсгийн хэрэгжилт;		
3.1. Олон нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журам сахихыг бусдаас шаардах чиглэлээр постер мэдээлэл бэлтгэн дотоод сүлжээнд байршуулах	Олон нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журам сахихыг бусдаас шаардах чиглэлээр мэдээлэл бэлтгэн мэдээллийн самбар болон газрын https://invest.ub.gov.mn/ сайтын Авлигын шинэтгэл дэд хэсгийн Авлигын эсрэг үйл ажиллагааны гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай талбарт 7 удаа байршуулав.	90 хувь
3.2. Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгуулах тухай постер мэдээлэл бэлтгэн дотоод сүлжээнд байршуулах	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан Иргэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар эдлэх эрхийн талаар мэдээлэл бэлтгэн мэдээллийн самбар болон газрын https://invest.ub.gov.mn/ сайтын Авлигын шинэтгэл дэд хэсгийн Авлигын эсрэг үйл ажиллагааны гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай талбарт 5 удаа байршуулав.	90 хувь
3.3. Гэмт хадлагаас эд хөрөнгө, өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг хуулийн хүрээнд хамгаалах чиглэлээр постер мэдээлэл бэлтгэн дотоод сүлжээнд байршуулах	Гэмт халдлагаас эд хөрөнгө, өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг хуулийн хүрээнд хамгаалах чиглэлээр мэдээлэл бэлтгэн мэдээллийн самбар болон газрын https://invest.ub.gov.mn/ сайтын Авлигын шинэтгэл дэд хэсгийн Авлигын эсрэг үйл ажиллагааны гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай талбарт 6 удаа байршуулав.	90 хувь
Дөрөв. Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн хэрэгжилт;		

<p>4.1.Олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвлүүлэх чиглэлээр нөлөөллийн постер мэдээлэл бэлтгэн дотоод сүлжээнд байршуулах</p>	<p>Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд холбогдох мэдээ, мэдээлэл мөн Авлигатай тэмцэх газрын одоо ашиглаж буй 110 тусгай дугаарыг 2026 оны 3 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл давхар ажиллуулах бөгөөд дээрх хугацаанаас хойш 110 дугаар хаагдаж, 11-10 дугаар ердийн горимоор урьдын адил ажиллах болсонтой холбогдуулан мэдээлэл газрын https://invest.ub.gov.mn/ сайт, мэдээллийн самбарын холбогдох талбарт 9 удаа байршуулан ажиллав.</p>	<p>85 хувь</p>
<p>4.2.Авлигатай тэмцэх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах, хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулах, бүртгэх, хянах, зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах</p>	<p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн захирамжаар нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2026 оны төлөвлөгөө”-ний төсөл боловсруулагдаж байгаа ба тус төлөвлөгөөтэй уялдуулан “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2026 оны төлөвлөгөө боловсруулах чиглэлтэй хүлээгдэж байна. Тус төлөвлөгөөний төсөлд Авлигатай тэмцэх чиглэлээр сургалт зохион байгуулах тухай ажил, арга хэмжээг төлөвлөсөн.</p> <p>Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн үйлчлэлд хамаарах мэдүүлэг гаргах үүрэг бүхий албан тушаалтнуудад тухай бүр мэдээлэл өгч, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг мэдүүлэх ажлыг Авлигатай тэмцэх газрын https://meduuleg.iaac.mn цахим системд хуулийн хугацаанд газрын хэмжээнд амжилттай зохион байгуулж Улсын Их Хурлын Хууль, зүйн байнгын хорооны 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн “Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах тухай” 5 дугаар тогтоолын хавсралтаар “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, оруулалтын мэдүүлэг (ХАСХОМ)-ийн маягт”-ын дагуу холбогдох бүртгэл хийв.</p>	<p>80 хувь</p>
<p>4.3.Газрын ажилтны Ёс зүйн дүрмийг шинэчлэн батлан гаргахын өмнө нийт ажилтнуудаас санал авч ажиллах</p>	<p>“Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын “Ёс зүйн дүрэм”-ийг холбогдох хууль тогтоомжид үндэслэн шинэчлэн боловсруулж, нийт ажилтнуудаас санал авч, Ёс зүйн дэд хорооны I, II дугаар хуралдаанаар дүрмийн төслийг хэлэлцүүлэн хурлын тэмдэглэлээр баталгаажуулан, Газрын даргын 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/45 дугаар тушаалаар батлуулж, дүрмийг газрын дотоод сүлжээнд НХОГ групп болон мэдээллийн самбарт QR болон постер хэлбэрээр бэлтгэн байршуулж, нийт ажилтан, албан хаагч нарт мэдээлэл хүргэж, танилцуулсан.</p>	<p>100 хувь</p>
<p>4.4.Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх чиглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх</p>	<p>Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/66 дугаар тушаалаар батлагдсан “Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээлэл гаргах, хүргүүлэх журам”-ын дагуу 2026 оны 1 дүгээр улирлын тайлан, мэдээг Газрын даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр албажуулан, 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 01/1425 дугаарын албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд хүргүүлэв.</p>	<p>73 хувь</p>

	<p>Хагас жилийн тайланг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд хүргүүлэхээр бэлтгэж байна.</p> <p>2026 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар Ер.Улаанбаатар.mn өргөдөл, гомдлын программд нийт 67 өргөдөл, гомдол бүртгэгдсэн. Үүнд: иргэнээс 63, албан хаагчаас 4 өргөдөл, гомдол бүртгэгдсэн ба хугацаандаа шийдвэрлэгдсэн 49 буюу 73 хувь, судлагдаж байгаа 18 буюу 26 хувь, хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл, гомдол бүртгэгдээгүй байна.</p> <p>Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног 12 цаг 34 минут байна.</p> <p>Газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/177 дугаар таушаалаар батлагдсан “Өргөдөл гомдол, хүлээн авах шийдвэрлэх, хяналт тавих журам”-ын 2.4, 2.5, 6.1, 6.3-т заасны дагуу иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг бүртгэл хөтлөн, удирдлагад танилцуулж, холбогдох албан хаагчид шилжүүлэн, хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэхэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Тайлант хугацаанд нийт 67 өргөдөл гомдлыг дараах байдлаар хяналт тавин ажиллав.</p> <ul style="list-style-type: none"> ✓ Өдөрт нь багтаан хүлээн авахыг сануулсан -67 удаа ✓ Өдөрт нь багтаан шилжүүлэхийг сануулсан-67 удаа ✓ Явцын тэмдэглэл хөтлөхийг сануулсан- 74 удаа ✓ Буцаалт 3 хоногт хийхийг сануулсан-5 удаа ✓ Холбогдох файл хавсарган шийдвэрлэхийг сануулсан-70 удаа нийт давхардсан тоогоор 283 удаа утсаар болон биечлэн сануулан бүртгэл хөтлөн ажиллав. 	
Тав.Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д заасан саналыг авсан эсэх:		
<p>5.1.Захиргааны хэм хэмжээний актын төслийг тухайн захиргааны байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт 30-аас доошгүй хоногийн хугацаанд байрлуулж ажиллах</p>	<p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/465 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангуулан Газрын даргын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гарсан 57 тушаалын төсөл боловсруулан холбогдох удирдах албан тушаалтнаар хянуулж бүртгэл хийв.</p>	<p>100 хувь</p>
Зургаа.Бусад чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх ажил:		


<p>6.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмын хэрэгжилтийн байдал</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах ажлын хүрээнд манай газар Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 25 төсөл, арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан зарласан байна. Нийт төрийн худалдан авах ажиллагааны https://user.tender.gov.mn/mn цахим системээр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 24 ажил, цахим дэлгүүрээс худалдан авах 1 ажил зарласан. Тендер шалгаруулалтын явц нь гүйцэтгэгчийг шалгаруулж гэрээ байгуулах эрх олгож гэрээ байгуулсан 21 ажил, гэрээ байгуулах эрх олгосон 1 ажил, тендерийн үнэлгээ хийгдэж байгаа 1 ажил, Сангийн яаманд гомдол гарсан 1 ажил тус тус байна.</p>	<p>100 хувь</p>
<p>6.2.Албан тушаалтан хандив авах, давхар ажил эрхлэх, төлбөр авах, төлөөлөл хэрэгжүүлэх зэрэг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн эсэх</p>	<p>Газрын www.invest.ub.gov.mn албан ёсны сайтын авлигын эсрэг шинэтгэл дэд цэсийн Авлигын эсрэг нэгдье сэдэвт постер талбарт Албан тушаалтан хандив авах, давхар ажил эрхлэх, төлбөр авах, төлөөлөл хэрэгжүүлэх зэрэг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хориглолт, хязгаарлалтын чиглэлээр 6 мэдээлэл байршуулсан.</p>	<p>90 хувь</p>
<p>6.3.Албаны үүргээ хэрэгжүүлэх явцад үл ойлгогдохуйц нөхцөл байдал үүсгэсэн, ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл байдалд шийдвэр гаргасан, үйл ажиллагаа эрхэлсэн эсэх</p>	<p>Газрын даргын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гарсан “Үнэлгээний хороо байгуулах тухай” тушаалаар батлагдсан төсөл, арга хэмжээнд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүний нарийн бичгийн даргад Хувийн ашиг сонирхлын нөхцөл үүсэж болзошгүй, үүсэх нөхцөл байдал үүссэн буюу аливаа хэлбэрээр шийдвэрт нөлөөлөхийг оролдсон тохиолдол бүрийг мэдэгдэж хэвших талаар чиглэл өгөв.</p>	<p>100 хувь</p>
<p>Дундаж биелэлт</p>		<p>94,9</p>

БИЕЛЭЛТТЭЙ ТАНИЛЦСАН:
ГАЗРЫН ДАРГА

БИЕЛЭЛТИЙГ ХЯНАСАН:

ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Б.ГАНЗОРИГ

Ц.ТУРБАДАМ

А.СОЛОНГО

А.СОЛОНГО